

ТАНИЛЦУУЛГА

1. **Эрдэнэцогтын Сарантогосыг Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилуулахаар танилцуулж байна**

2. 1975 онд Улаанбаатар хотод төрсөн

3. 48 настай

4. Эмэгтэй

5. Гэр бүлийн байдал: Нөхөр, 2 хүүхэдтэй

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

1997 онд Монгол Улсын Их сургуулийн Олон улсын харилцааны дээд сургуулийг олон улсын харилцаагаар базалаар, 2002 онд Япон Улсын Васэдагийн Их сургуулийг олон улсын харилцаагаар магистр, 2010 онд Австралийн Холбооны Улсын Аделаидын Их сургуулийг олон улсын эдийн засгийн ухаанаар магистрын зэрэгтэй тус тус төгссөн. "Тэргүүн шадар" дипломат цолтай. Англи, орос, япон хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал:

1997-1998 онд Гадаад харилцааны яамны Нэгдүгээр газарт туслах мэргэжилтэн, 1999-2002 онд Гадаад харилцааны яамны Улс төрийн газарт мэргэжилтэн, 2002-2004 онд Гадаад харилцааны яамны Бодлого, төлөвлөлтийн газарт гуравдугаар нарийн бичгийн дарга, 2004-2007 онд Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яаманд гуравдугаар нарийн бичгийн дарга, 2007-2010 онд Гадаад харилцааны яамны Азийн газарт хоёрдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд Гадаад харилцааны яамны Стратеги төлөвлөлт, хяналт-шинжилгээний газарт нэгдүгээр нарийн бичгийн дарга, 2012-2016 онд Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яаманд зөвлөх, Элчин зөвлөх, 2016 онд Гадаад харилцааны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч, 2016-2022 онд Гадаад харилцааны яамны Ази, Номхон далайн орнуудын газарт дэд захирал, захирал, 2022 оны 05 дугаар сараас Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа (жилээр):

Төрийн албанд 25 жил

Дипломат албанд 25 жил

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэслэл:

Мэргэжлийн үр чадвар, удирдах ажлын дадлага туршлага, гадаад хэлний мэдлэгийг харгалзан энэхүү албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

Гадаад харилцааны сайдын саналаар

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан: Төрийн захиргааны удирдлагын газрын захирал

С.Золжаргал

Боловсруулсан: Төрийн захиргааны удирдлагын газрын атташе

Л.Халиун

13. Албан тушаалд томилох үед өгсөн үүрэг, зөвлөмж

2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр